

UCS 1601A:2025

ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ




Нийтийн тээврийн зогсоолын зорчигчийн хүлээлгийн
танхимд тавигдах ерөнхий шаардлага

ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Нийтийн тээврийн зогсоолын зорчигчийн хүлээлгийн
танхимд тавигдах ерөнхий шаардлага

*Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 25/10-р тогтоолоор батлав.*



ГАРЧИГ

1. Хамрах хүрээ	4
2. Норматив эшлэл	4
3. Нэр томъёоны тодорхойлолт	4
4. Ерөнхий шаардлага	5
5. Төлөвлөлтийн шаардлага	6
6. Ухаалаг болон иж бүрэн хүлээлгийн танхимд тавигдах нэмэлт шаардлага	7
7. Халаалт, агаар сэлгэлт	8
8. Шалгах хуудас	9
Ашигласан материалын жагсаалт	10

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Нийтийн тээврийн зогсоолын хүлээлгийн танхим	5
Зураг 2. Хүлээлгийн танхимын дотор харагдах байдал	7
Зураг 3. Ухаалаг хүлээлгийн танхим	8
Зураг 4. Халаалтын тоног төхөөрөмж	9

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Хүлээлгийн танхимын ангилал, иж бүрдэл	6
Хүснэгт 2. Шалгах хуудас	9



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 25/10

Улаанбаатар хот

Зорчигч тээврийн үйлчилгээний бүлэгт
хамаарах хотын стандартыг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10¹ дүгээр зүйлийн 10^{1.1} дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах эрхийг хангахад чиглэсэн “Зорчигч тээврийн үйлчилгээ” бүлэг хамаарах UCS1601A:2025 “Нийтийн тээврийн зогсоолын зорчигчийн хүлээлгийн танхимд тавигдах ерөнхий шаардлага” хотын стандартыг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан хотын стандартыг олон нийтэд сурталчлан, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоолыг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүсчилсэн хөгжлийн хороо (Л.Ариунтуяа)-д даалгасугай.

ДАРГА

А.БАЯР

17-10-10

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 25/10
дугаар тогтоолын хавсралт

ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

UCS 1601A:2025

“НИЙТИЙН ТЭЭВРИЙН ЗОГСООЛЫН ЗОРЧИГЧИЙН ХҮЛЭЭЛГИЙН ТАНХИМД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА” ХОТЫН СТАНДАРТ

1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү стандартыг нийслэл хотын хэмжээнд нийтийн тээврийн зогсоол дахь зорчигчийн хүлээлгийн танхимыг төлөвлөх, гүйцэтгэх, угсрах үйл ажиллагаанд даган мөрдөнө.

2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү стандартад эш татсан дараах барилгын норм ба дүрэм, стандартын шаардлагыг хангах ба өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалыг үндэслэл болгоно.

- Авто тээврийн тухай хууль;
- Авто замын тухай хууль;
- Эрчим хүчний тухай хууль;
- Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль
- Монгол Улсын Зар сурталчилгааны тухай хууль;
- БНБД 30.01.04 Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм;
- MNS 4597: 2014 Замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага;
- MNS 5012:2021 Нийтийн тээвэр. Ангилал ба үйлчилгээнд тавих. Ерөнхий шаардлага;
- MNS 5879:2012 Нийтийн тээврийн замналын зогсоол. Ангилал. Техникийн шаардлага;
- БНБД 32.101.17 Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолын төлөвлөлт;
- UCS 1601B:2022 Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолд тавих ерөнхий шаардлага.

3. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Хүлээлгийн танхим - нийтийн тээврээр зорчигчид чиглэлийн тээврийн хэрэгслийг хүлээх хугацаанд ая тухтай орчин бий болгож, түр байрлах зориулалттай, халаалт, агаар сэлгэлт бүхий битүү байгууламж;

Энгийн хүлээлгийн танхим - дундын зогсоол дагуу байрлуулах, цөөн хүний багтаамж бүхий битүү байгууламж;

Ухаалаг хүлээлгийн танхим - харилцаа холбоо, дохиолол, системийн тусламжтайгаар эрчим хүч хэмнэх, зорчигчдын ая тухтай байдлыг хангах, шаардлагатай мэдээллээр хангах функц бүхий дулаан байгууламж;

Иж бүрэн хүлээлгийн танхим - зорчигчдыг анхдагч хэрэгцээ, мэдээллээр хангах иж бүрэн тоноглол бүхий хүлээлгийн дулаан байгууламж;

Бие даасан дэд бүтэц - инженерийн хангамжийн төвлөрсөн системд холбогдоогүй, эсвэл холбогдох боломжгүй газарт байрлах ус хангамж, ариутгах татуурга, эрчим хүчний бие даасан систем;

Нийтийн тээврийн хэрэгсэл - зорчигч тээвэрлэхэд зориулсан бүх төрлийн автобус, такси, цахилгаан тээврийн хэрэгсэл;

Замналын зогсоол - нийтийн тээврийн автобусны зогсоолын тэмдэг бүхий зорчигч буух, суух цэг;

Эхний ба эцсийн зогсоол - батлагдсан замналаар нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөн эхлэх ба дуусах цэг;

Дундын зогсоол - нийтийн тээврээр зорчих хөдөлгөөний урсгал үүсэх болон тээврийн үйлчилгээний төвлөрсөн цэгүүдэд хамгийн ойр байхаар замналын дагуу байрлуулсан цэгүүд;

Замнал - эцсийн ба төгсгөлийн буудлуудын хооронд үйлчилгээний автобус явах баталсан зам;

Мэдээллийн самбар - зогсоолын нэр, дайран өнгөрөх замналын дугаар, нэр, зураглал, цагийн хуваарь болон нийтийн тээврийн холбогдолтой бусад мэдээллийг агуулсан самбар.

4. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

4.1. Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолын хүлээлгийн танхим нь зорчигч иргэдийн эрүүл аюулгүй, тав тухтай байх нөхцөлийг бүрдүүлэх дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- үндсэн хийц, материал нь бат бөх, эдэлгээ даах чанартай, байгаль цаг уурын эрс тэс нөхцөлд тохиромжтой байх. /-40°C-аас +40°C/;
- хөгжлийн бэрхшээлтэй хүний хүртээмжтэй байдлыг бүрэн хангаж тоноглогдсон байна;
- үзэгдэх орчныг хангах зорилгоор хүлээлгийн танхимын нүүр болон хажуу талыг шилээр хийх ба хатжуулсан шилийг ашиглана;
- нүүлгэн шилжүүлэх, дахин угсарч ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн байна;
- дулаан алдагдал багатай, битүүмжлэл сайтай байх;
- явган хүний зорчих хэсэгт саад учруулахааргүй төлөвлөх;
- нийтийн тээврийн зогсоолын нэрийг ил харагдах хэсэгт байрлуулах;
- гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор нөөц хаалгатай байж болно.



Зураг 1. Нийтийн тээврийн зогсоолын хүлээлгийн танхим (жишээ зураг)

- 4.2. Энэхүү стандартад заасан шаардлагуудыг харгалзан үзэж эрх бүхий мэргэжлийн байгууллагын боловсруулсан зураг төслийн дагуу барьж байгуулах ба холбогдох чиг үүргийн байгууллагатай заавал зөвшилцөнө.
- 4.3. БНБД 81-70-05 “Цахилгааны ажил” болон БНБД 21-01-02 “Барилга байгууламжийн галын аюулгүй байдал”-ын норм, дүрмийг тус тус бүрэн хангасан байна.
- 4.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хүртээмжтэй байдлыг бүрэн хангаж, сонсголын бэрхшээлтэй иргэнд зориулан зарлан мэдээлэх тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.

5. ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА


- 5.1. Нийтийн тээврийн буудлын төрөл, зэрэглэл, зорчигч үйлчилгээний ачааллаас шалтгаалж энгийн, ухаалаг, иж бүрэн гэсэн 3 төрлийн хүлээлгийн танхимаас аль тохирохыг сонгон төлөвлөнө.
- 5.2. Хүлээлгийн танхим нь хүснэгт 1-д заасан ангилал, харгалзах иж бүрдэлтэй байна.

Хүснэгт 1. Хүлээлгийн танхимын ангилал, иж бүрдэл

№	Иж бүрдэл	Хүлээлгийн танхимын ангилал		
		Энгийн	Ухаалаг	Иж бүрэн
1	Халаах хэрэгсэл	+	+	+
2	Сандал	+	+	+
3	Гэрэлтүүлэг	+	+	+
4	Чиглэлийн мэдээллийн самбар	+		
5	Ухаалаг мэдээллийн самбар /автобус ирэх хугацаа, агаарын чанарын үзүүлэлт/		+	+
6	Халаалт, агаар сэлгэлтийн систем		+	+
7	Камер	+	+	+
8	Ариутгах тоног төхөөрөмж			+
9	Агаар цэвэршүүлэгч			+
10	Утасгүй интернэт сүлжээ /Wi-Fi/		+	+
11	Тавцан	+	+	+
12	Гар утас цэнэглэгч	+	+	+
13	Нарны зай хураагуур		+	+
14	Ариун цэврийн өрөө			+
15	Зай талбайн хэмжээ	15м ² хүртэл	20-30м ² хүртэл	

- 5.3. Хүлээлгийн танхимын зай хэмжээг тооцохдоо зорчигч, үйлчлүүлэгчийн ачаалал, гадна орчны орон зайн хүртээмжтэй байдлыг харгалзан үзэж нарийн хэмжээг тогтооно.
- 5.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эргономикт тохируулан орц, гарцыг босгогүй төлөвлөнө.
- 5.5. Гэрэлтүүлэг нь 40-60Вт хүчин чадалтай LED гэрэл байна.
- 5.6. Дуу, дүрсний өндөр чанартай хяналтын камер /4K/ байрлуулна.
- 5.7. Шалны гадаргуу нь цэвэрлэхэд хялбар, халтиргаа, гулгаа үүсэхээргүй барзгар гадаргуутай байна.
- 5.8. Гар утас, зөөврийн компьютер цэнэглэх залгуур, USB оролттой байх.

5.9. Нийтийн тээврийн үйлчилгээний маршрут, чиглэлийн талаарх мэдээлэх самбартай байна.



Зураг 2. Хүлээлгийн танхимын дотор харагдах байдал (жишээ зураг)

5.10. Нийслэлээс хэрэгжүүлж буй бодлого үйл ажиллагаа болон хамтран ажиллагч, дэмжигч, спонсор байгууллага, аж ахуйн нэгжийн сурталчилгаа байрлуулах орон зайг төлөвлөж болно.

5.11. Хүлээлгийн танхимын гадна орчин нь UCS 1601B:2022 “Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолд тавих ерөнхий шаардлага”-ыг хангасан иж бүрдэлтэй байна.

5.12. Энгийн хүлээлгийн танхимыг зорчигчдын тоо харьцангуй цөөн, дундын зогсоолын дагуу байрлуулах нь илүү тохиромжтой.

5.13. Явган зорчигчийн хөдөлгөөнд саад учруулахааргүй байршилд суурилуулна.

6. УХААЛАГ БОЛОН ИЖ БҮРЭН ХҮЛЭЭЛГИЙН ТАНХИМД ТАВИГДАХ НЭМЭЛТ ШААРДЛАГА

6.1. Ухаалаг хүлээлгийн танхимыг хотын төв орчимд зорчигчдын ачаалал ихтэй байршилд сонгох нь давуу талтай бөгөөд дараах нэмэлт шаардлагыг хангасан байна.


6.1.1. Нийтийн тээврээр зорчих карт цэнэглэх, тасалбар худалдан авах автомат машин байрлуулна.

6.1.2. Утасгүй интернэтийн сүлжээнд холбогдох боломжтой.

6.1.3. Мэдрэгч бүхий автомат хаалгатай байна.

6.1.4. Эрчим хүчний хэрэглээг хэмнэх, төвлөрсөн эрчим хүч болон сэргээгдэх эрчим хүчийг хослуулах зорилгоор нарны зай хураагууртай байж болно.

- 6.2. Иж бүрэн хүлээлгийн танхимыг хөдөлгөөний эрчим ихтэй, зорчигчид олноор төвлөрсөн зах худалдааны төвийн орчим эсвэл автобусны эцсийн зогсоол орчимд төлөвлөх нь илүү оновчтой.
- 6.2.1. Автобусны жолооч, үйлчлүүлэгчдийн хэрэгцээнд нийцсэн, хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй ариун цэврийн өрөөтэй байна.
- 6.2.2. Гар ариутгах тоног төхөөрөмж суурилуулах.
- 6.2.3. Дэд бүтцийн хүртээмжээс шалтгаалж төвлөрсөн эсвэл бие даасан ариутгах систем, ус хангамжтай байна.
- 6.2.4. Утасгүй интернэтийн сүлжээнд холбогдох боломжтой.
- 6.2.5. Төрийн үйлчилгээний автомат төхөөрөмж /киоск/, Бэлэн мөнгөний автомат машин (АТМ), ус, ундаа борлуулах автомат машин зэргийг байрлуулж болно.



Зураг 3. Ухаалаг хүлээлгийн танхим (жишээ зураг)

7. ХАЛААЛТ, АГААР СЭЛГЭЛТ

- 7.1. Халаалтын тоног төхөөрөмжийн хүчин чадал нь зай талбайгаас хамаарч хүрэлцээтэй байхаар төлөвлөж, 220кВт-ын эх үүсгэвэртэй, хүйтний улиралд дотор агаарын хэм +10С-ээс доошгүй байна.
- 7.2. Хүйтний улиралд халаах, халууны улиралд сэрүүцүүлэх халаалт, агаар сэлгэлтийн төхөөрөмжтэй байна. Тухайлбал: Дулаан хөшиг буюу Air curtain, цахилгаан халаагуур /тень/, агааржуулагч гэх мэт.

7.3. Халаалтын систем нь орчны агаарын хэмийг мэдэрдэг автомат тохируулгатай байна.

7.4. Эрчим хүчний эх үүсгэврийг сэргээгдэх эрчим хүчтэй хослуулан төлөвлөж болно.



Зураг 4. Халаалтын тоног төхөөрөмж (жишээ зураг)

8. ШАЛГАХ ХУУДАС

Хүлээлгийн танхимд тавигдах ерөнхий шаардлагыг хангасан эсэхийг үнэлэхэд (Хүснэгт 2)-ын дагуу хянан шалгана.

Хүснэгт 2. Шалгах хуудас

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Батлагдсан ажлын зураг төсөлтэй эсэх	☐	☐
2	Зохих иж бүрдэл хангасан эсэх	☐	☐
3	Утас цэнэглэгч, USB оролтууд хэвийн ажиллагаатай эсэх	☐	☐
4	Хяналтын камер хэвийн ажиллагаатай эсэх	☐	☐
5	Галын болон цахилгааны аюулгүй байдлын нормыг хангасан эсэх	☐	☐
6	Халаалт, агаар сэлгэлтийн тоног төхөөрөмж нь шаардлага хангасан эсэх	☐	☐
7	Иж бүрэн хүлээлгийн танхим нь ус хангамж, ариутгах системд холбогдсон эсвэл бие даасан системтэй эсэх,	☐	☐

Тайлбар: Дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол **“Тийм”** хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол **“Үгүй”** хэсгийг тэмдэглэнэ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- Авто тээврийн тухай хууль;
- MNS 5879: 2012 Нийтийн тээврийн замналын зогсоол. Ангилал. Техникийн шаардлага;
- БНбД 32.101.17 Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолын төлөвлөлт;
- UCS 1601B:2022 Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолд тавих ерөнхий шаардлага.

[illegible]



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР



Хан-Уул дүүрэг, 23 дугаар хороо, Наадамчдын зам 1201,
Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор Б байр



72707700



www.uds.ub.gov.mn



Хот байгуулалт, хотын стандартын газар